



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 17 өдөр

Дугаар 06

Дархан

“Боловсрол-2032” хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “е”, Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Боловсрол-2032” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.


2. “Боловсрол-2032” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж, биелэлт, үр дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (Б.Азжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.НАСАНБАТ

Дархан-Уул аймгийн ИТХ-ын
2021 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн
06 дугаар тогтоолын хавсралт



“Боловсрол-2032”

Дархан-Уул аймгийн боловсролын зорилтот хөтөлбөр

Дархан-Уул аймаг
2021 он

“Боловсрол- 2032” зорилтот хөтөлбөр

Агуулга

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Хөтөлбөрийн хамрах хүрээ

Гурав. Зорилгын томъёолол

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтууд

Тав. Хэрэгжих хугацаа

Зургаа. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Долоо. Үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

Нэг. Нийтлэг үндэслэл

Нэг. Өнөөгийн нийгэмд гарч байгаа олон талт өөрчлөлтүүд нь боловсролын салбарт шинэ сорилт, боломжуудыг бий болгож байна. Үүнд, мэдээллийн технологийн дэвшлийг бүтээлчээр ашиглах, сургахаас суралцахуй руу шилжих шилжилт, боловсролын чанар, хүний хөгжилд мэдлэг боловсролын үүргийг ойлгох шинэ хандлага зэрэг багтана. Мөн орон нутгийн түвшинд боловсролын салбарын бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох, өөрийгөө тасралтгүй хөгжүүлдэг багш, суралцагчдын бүтээлч үйлийг дэмждэг сургууль, хүүхдийн авьяас, сонирхол, чадварыг нээн хөгжүүлдэг тогтолцоог дэмжих нь чухал юм.

Дэлхийн улс орнууд боловсролын бодлогоо шинжлэх ухаан, технологийн хөгжил, дэвшил, нээлттэй нийгэм, ирээдүйд зохицон амьдрах чадвартай иргэнийг бэлтгэхэд чиглүүлж буй өнөө үед манай улсын тухайд нийгмийн амьдралын таатай орчин, хэм хэмжээг бий болгох, түүнд дасан зохицож амьдрах чадвартай, иргэншсэн монгол хүнийг төлөвшүүлэх, хүүхдийн сурч боловсрох хүсэл сонирхол, хийж бүтээх тэмүүллийг боловсролын бүх түвшин бүрт дэмжиж ажиллахыг боловсролын зорилго болгон дэвшүүлсэн.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод боловсролын салбарыг хөгжүүлэх зорилго зорилтуудыг үе шаттай хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд эхний үе шат буюу 2030 он хүртэлх боловсролын салбарыг хөгжүүлэх үндсэн зорилт нь “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе” хэмээн тодорхойлж улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ гэж тусгасан.

Төрөөс боловсролын салбарын бодлогын баримт бичгүүдэд тусгасан урт, дунд хугацааны хөгжлийн бодлогуудыг орон нутагт хэрэгжүүлэх, Дархан-Уул аймгийн боловсролын салбарт тулгамдсан асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх, аймгийн боловсролын салбарын онцлог нөхцлийг харгалзсан хөгжлийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх зорилгоор “Боловсрол-2032” зорилтот хөтөлбөрийг “багшийн хөгжил, хүүхдийн хөгжил, сургалтын орчин” гэсэн гурван үндсэн зорилтын хүрээнд боловсрууллаа.

Энэхүү хөтөлбөрийг боловсруулахад боловсролын салбарын бодлогын баримтын судалгаа, процессийн шинжилгээ, асуудал шалтгааны шинжилгээ, боловсролын салбарын гадаад ба дотоод орчны шинжилгээ, нөлөөллийн үнэлгээний арга, эрсдэлийн нөлөөллийн шинжилгээ зэргийг ашиглаж түүвэр судалгаа, ажиглалт судалгаа болон харьцуулан жиших, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргыг хэрэглэлээ.

Хоёр. Хөтөлбөрийн хамрах хүрээ

Энэхүү хөтөлбөр нь төрөөс боловсролын талаар баримтлах үндсэн бодлого чиглэлийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ орон нутаг өөрийн нөөц бололцоо, удирдлага зохион байгуулалтад тулгуурлан багш, хүүхдийн хөгжлийг дэмжиж, сургалтын орчинг сайжруулснаар аймгийн боловсролын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэн боловсролын бүх шатанд чанартай боловсрол олгоход чиглэгдсэн болно.

Хөтөлбөр нь багшийн хөгжил, хүүхдийн хөгжил, сургалтын орчин гэсэн гурван багц хүрээг хамарсан бөгөөд хөтөлбөрт туссан зорилтуудын нэр томъёог доорх байдлаар авч үзнэ. Үүнд:

Багшийн хөгжил: Багшийн мэргэжлийн чадамж (мэдлэг, чадвар, хандлага), үнэт зүйлийг тодорхойлсон багш мэргэжлийн үндэсний стандартыг бүрэн хангасан өндөр түвшний чадварлаг багштай болох үндсэн зорилтыг хангана.

Багш мэргэжлийн стандарт: Багшийн мэргэжлийн чадамжийг БШУЯ-наас баталсан стандарт шалгуур үзүүлэлтээр авч үзнэ.

Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил: Мэргэжлийн буюу багшид зайлшгүй шаардагдах чадамжийг хөгжүүлэх, туршлага хуримтлуулахад чиглэсэн тасралтгүй үйл ажиллагаа¹.

Чадварлаг багш: Мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн өндөр чадварыг эзэмшсэн, өндөр зэрэглэлийн сургалт, арга зүй, технологи үүсгэсэн, сурагчдын сургалтын амжилтаар баталгаажсан багш.

Сургалтын орчин: Сургалтын орчин гэдэг нь сургалтын лаборатори, кабинет, зориулалтын байр, анги танхимын зэрэгцээ багш, суралцагчдыг эрүүл аюулгүй,

бүрэн хамгаалагдсан орчинд сурч хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлсэн хүүхдэд ээлтэй сургууль, цэцэрлэг бий болгохыг хэлнэ.

Хүүхдийн хөгжил, төлөвшил: Хүүхэд бүр байгалиас заяасан авьяас, чадвараа нээн хөгжүүлснээр бага наснаасаа мэргэжлийн чиг баримжаатай болж, улмаар хийж бүтээх чиглэл, ажил, мэргэжлээ зөв сонгон, цаашид эзэмшсэн мэргэжлээрээ үр бүтээлтэй хөдөлмөрлөж, сайхан амьдрах цогц мэдлэг, чадвартай иргэн болж төлөвших нөхцөл бололцоог бүрдүүлэхийг хэлнэ.

Нийгмийн хөгжлийн олон талт хэрэгцээ шаардлаганд тулгуурлан боловсролын байгууллагуудын материаллаг бааз, сургалтын орчинг сайжруулах замаар суралцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлэх явдал чухал байна. Ерөнхий боловсролын сургуулиудыг хүчин чадал, байршил, хүүхдийн тоо, сургуулийн онцлог, төрөлжүүлэн хөгжүүлэх шаардлага зэрэг хүчин зүйлсийг тооцон өөрчлөлтийн менежментийн бодлогыг дунд хугацаанд хэрэгжүүлж ирээдүйн хэв шинжийг зөв бүрдүүлэх нь Боловсрол-2032 зорилтот хөтөлбөрийн нэг чухал үндэслэл болно.

Гурав. Зорилгын томъёолол

“БОЛОВСРОЛ 2032” зорилтот хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн алсын хараа, эрхэм зорилго, зорилго нь “АЛСЫН ХАРАА-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, БШУЯ-ны боловсролын салбарын шинэчлэлийн бодлого зорилтууд, аймаг орон нутгийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан боловсролыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого, зорилтуудад үндэслэсэн болно.

Алсын хараа: Хувь хүн, хамт олон, нийгмийн бүлгүүдийн амьдралыг өөрчлөн сайжруулах чиглэлээр сурч хөгжих, соён гэгээрүүлэх чиглэлээр боловсролын үйлчилгээг үзүүлэх.

Эрхэм зорилго: Хүн бүр чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэхэд аймгийн боловсролын байгууллагуудын өнөөгийн хүрсэн түвшинд суурилан байгууллага бүр өөрийн онцлогийг илэрхийлсэн давуу талд үндэслэсэн хөгжлийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх, боловсролын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, үр ашигтай байдлаар үзүүлэхэд чиглэнэ.

”Боловсролын үйлчилгээг: “нийтэд хүртээмжтэй, чанартай, өгөөжтэйгээр үзүүлэх” гэдэг нь эрхэм зорилгын хураангуй болно.

ҮНЭТ ЗҮЙЛ

- Бүтээлч, бие даан суралцах арга барилтай, хүмүүжил төлөвшил бүхий хүүхэд
- Чанартай, хүртээмжтэй боловсрол
- Чадварлаг багшлах боловсон хүчин
- Ур чадвартай, зарчимч удирдлага
- Хүлээн зөвшөөрөгдсөн сургалт

ЗАРЧИМ

Хөтөлбөрийн зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг мөрдлөг болгоно. Үүнд:

- Монгол улсын хууль, тогтоомж болон бусад холбогдох бодлогын баримт бичиг, хөтөлбөртэй нийцсэн байх;
- Олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй, тэгш хөгжих боломжтой, уян хатан чанартай байх;
- Хөтөлбөрийн хэрэгжилт нь хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага, удирдах ажилтнууд болон багш, ажилтнуудын хүсэл эрмэлзэл, тэдний хоорондын харилцан итгэлцэл, хамтын ажиллагаан дээр тулгуурлах;
- Хөтөлбөр нь төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоо, иргэд, гадаадын хандивлагч, сонирхогч бүх талын дэмжлэгт түшиглэх зэрэг болно.
- Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт нь институцэд суурилсан байх;

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтууд

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх гурван чиглэлийн хүрээнд нийцүүлэн дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Зорилт 1. Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангаж сургалт хөгжлийг чанаржуулах чиглэлийн хүрээнд:

1.1. Багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролыг тасралтгүй дээшлүүлж, суралцагчдын хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана.

1.2. Багш ажлын байрандаа хамтран, харилцан бие биеэ хөгжүүлэх мэргэжлийн тасралтгүй хөгжлийн бүлэг, менторинг зэрэг шинэлэг арга хэлбэрийг нэвтрүүлэх, багш нарыг сургаж бэлдэх, холбогдох туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.

1.3. Багш нарын мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран багшийн мэргэжлийн бэлтгэлийн тасралтгүй өсөлтийг хангана.

1.4. Багшийн мэргэжлийн зэргийг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ судалгаа арга зүйг сайжруулах чиглэлээр их дээд сургуулиудтай хамтран ажиллаж бүтээл туурвих, судалгаа хийх үйл ажиллагааг дэмжинэ.

1.5. Нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон суралцагчид орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлсэн байна. Багш нарт техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан шинэ ур чадвар дадал эзэмшүүлэх замаар боловсролыг тасралтгүй чанартай олгоно.

1.6. Багшийн мэргэжил, эрдэм шинжилгээ, судалгаа- арга зүйн чадамжийг тасралтгүй хөгжүүлж хөдөлмөрийн үнэлэмжийг бодитой болгох, үр дүнд суурилсан урамшууллын тогтолцоог бий болгох.

1.7. Багшийн сургалт-сувилалын төв, багшийн орон сууцны төслийг дэмжинэ.

Зорилт 2. Хүүхдийн хөгжил, төлөвшлийн талаар:

2.1. Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх клуб, дугуйлангийн орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр хүүхэд бүрт авьяас чадвараа хөгжүүлэх тэгш боломжийг олгоно.

2.2. Байгалийн шинжлэх ухаан, мэдээллийн технологи, техник сэтгэлгээг хөгжүүлэх дугуйлан, зохион бүтээх авьяастай хүүхэд залуучуудыг нэгтгэсэн “Залуу техникчдийн клуб”-ыг байгуулна.

2.3. Хүүхдийн ном, хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон бүтээл туурвилыг нэмэгдүүлнэ.

2.4 Хүүхэд багачуудад иргэний боловсролыг олгох, тэднийг ёс зүйтэй иргэн болгоход чиглэсэн арга хэмжээнүүдийг өргөнөөр зохион байгуулна.

Зорилт 3: ЕБС, цэцэрлэгийн сургалтын орчин сайжруулах хүрээнд:

3.1. Сургалтын танхим, лаборатори, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний хүртээмжийг сайжруулна.

3.2. Сургууль, цэцэрлэг, соёл спортын барилга шинээр барих, өргөтгөл хийх, инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох, цахилгаан дулааны найдвартай эх үүсвэрээр хангах, сургууль цэцэрлэгийн барилга байгууламжуудын стандартуудыг хэрэгжүүлэх замаар багш суралцагчдыг эрүүл аюулгүй, хамгаалагдсан орчинд сурч хүмүүжих орчин нөхцөлийг бүрдүүлсэн хүүхдэд ээлтэй сургууль цэцэрлэгийг бий болгоно.

3.3. Теле хичээл, зайн болон цахим сургалтыг хөгжүүлж багш нарт техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан шинэ ур чадвар дадал эзэмшүүлэх замаар онцгой нөхцөлд боловсролыг тасралтгүй чанартай олгох тогтолцоо орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

3.4. Сургуулийг хүчин чадал байршил, хүүхдийн тоо, сургуулийн онцлог, ирээдүйн хэрэгцээ зэрэг хүчин зүйлсийг тооцон өөрчлөлтийн менежментийн бодлогыг урт хугацаанд хэрэгжүүлж шаардлагатай хэв шинж бүтцэд үе шаттайгаар шилжүүлнэ.

Тав. Хэрэгжих хугацаа

№	Хөтөлбөр хэрэгжих үе шат	
1	I үе шат	2021-2024 он
2	II үе шат	2025-2028 он
3	III үе шат	2029-2032 он